

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 26 дугаар тэмдэглэлд:

“XIX.3. Улсын Их Хурал болон Засгийн газрын тогтоолоор батласан Төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

1. Төрөөс баримтлах бодлогын баримт бичигт туссан асуудлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь ирүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нарт үүрэг болгов.

2. Төрөөс баримтлах бодлогын баримт бичигт туссан боловч хэрэгжилт хангалтгүй, удаашралтай байгаа асуудлыг эрчимжүүлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах, хэрэгжих хугацаа нь дуусгавар болсон бодлогын баримт бичигт эцсийн шатны болон хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, хэрхэн хэрэгжсэн талаарх эцсийн үр дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг холбогдох сайд нарт даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР